

ЗАХИРАЛ, НИЙГМИЙН АЖИЛТАНТАЙ ХИЙХ ЯРИЛЦЛАГЫН ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТ

Нэг. Сургуулийн эерэг таатай уур амьсгал

1. Танай сургуулийн гол ололт амжилт, бахархдаг зүйл юу вэ?
2. Та ажилдаа дуртай юу? Ажлаа хийхэд танд саад болдог зүйл байдаг уу?
3. Сургуулийн үйл ажиллагааны талаар санал бодлоо илэрхийлэх боломжийг хэрхэн бүрдүүлдэг вэ?
4. Та мэргэжлийнхээ хувьд хөгжих боломж бүрдсэн байдаг ? Энэ талаар ямар нэгэн санал байдаг уу?

Хоёр. Бие махбодийн шийтгэл, хүчирхийллээс хамгаалагдсан байдал

1. Та бие махбодийн шийтгэл, хүчирхийлэл гэдгийг юу гэж ойлгож байна вэ?
2. Сургуулийн орчинд багш сурагчид бие махбодийн шийтгэл үзүүлэх, хүчирхийлэх тохиолдол гардаг уу? Ийм асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ? Үүнээс хэрхэн сэргийлэх вэ?
1. Багш нар хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэдэг үү? Ямар аргыг хэрэглэдэг вэ? Энэ асуудлаар сургуулиас сургалт мэдээлэл өгдөг үү? (загнаж зандрахаасаа илүү зөвлөх, тайлбарлах, ойлгуулах, буруу зүйл хийхэд цохиж зоддоггүй байх)
2. Багш нар ажлын байрандаа дарамт, хүчирхийллээс хамгаалагдаж чаддаг уу? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?
3. “Багшийн ёс зүйн дүрэм”-ийг дагаж мөрдөхөд хүндрэлтэй, ойлгомжгүй зүйл байдаг уу? Ямар?

Гурав. Сэтгэл зүйн дарамт, ялгаварлан гадуурхалтаас хамгаалагдсан байдал

1. Сурагчид, эцэг эхчүүд ямар нэг дарамттай байдалд орвол зөвлөгөө, тусламж авахаар танд ханддаг уу? Тийм бол ямар? Та хэрхэн шийдвэрлэдэг вэ?
2. Ялгаварлан гадуурхалтын асуудлаар та сургалт, мэдээллийн ажил зохион байгуулдаг уу?
3. Сургуулийн зүгээс хэлний цөөнх сурагчдыг хэрхэн дэмждэг вэ? Юу хийх хэрэгтэй байгаа вэ? (Үндэсний хэл, соёл, баяр наадам зэрэгт хүндэтгэлтэй хандаж энэ чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулдаг эсэх).
4. Танай сургуульд энэ жил хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа юу? Эдгээр хүүхдүүд сурах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлэх талаар гаргасан бодлого, шийдвэр байдаг уу? Цаашид юу хийх хэрэгтэй вэ? (*Нийгэмшүүлэх, бие даан амьдрахад сургах хичээлээс гадуур үйл ажиллагаа гэх мэт*)
5. Танай сургууль тусгай хэрэгцээт боловсролоор мэргэшсэн багштай юу? Багшийн хөгжлийг хэрхэн дэмждэг вэ?